



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 19

Номгон

Ажлын хэсэг томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6, 66.1.7 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах, зөвшөөрөл авахтай холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

2.Комиссын дарга: Д.Энхжаргал-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга

Гишүүд: М.Майжаргал:-Аймгийн Шүүхийн тамгын газрын дарга, Салбар зөвлөлийн гишүүн

Ц.Байгальмаа-Аймгийн ИТХ-ын Хууль эрх зүй, хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн дага

Б.Наранцэцэг- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Отгонтөгс -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Саруул- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.Саранчимэг- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Батцэцэг- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нигмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

642213163


Б.Батбаяр- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах
мэргэжилтэн

Т.Сандагдорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Д.Сарангарав-Төрийн албаны зөвлөлийн салбар
зөвлөлийн Нарийн бичгийн даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

2.Албан тушаалын тодорхойлолт шинэчлэх ажлыг Төрийн албаны
зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу шуурхай зохион байгуулж, хариуцлагатай
ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд, ажлын хэсгийг арга зүйгээр хангаж, тайланг
хуралдаанд танилцуулан, Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүлэхийг
Салбар Зөвлөлийн Нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(Д.Сарангарав)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ